



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ**

2025 оны 06 сарын 02

Улаанбаатар хот

Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх			
1.1 Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас, б/сошиал сувгууд, в/дотоод сүлжээ, г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх	-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; -Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх; -Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Жилдээ	2025.03.18-нд Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран, төрийн үйлчилгээг хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нээлттэй, ил тод, шуурхай хүргэхийн төлөө соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж видео контент хийж газрын цахим хуудсаар түгээж ажиллалаа. /хандалтын тоо 4200/ Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж “Нэг цэгийн үйлчилгээ цахим мэдээллийн тасаг”-т дараалалгүй үйлчлэх, тусгай цонхны үйлчилгээг нэвтрүүлэн, нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн талаарх хараагүй иргэдэд зориулсан “брайл” үсэг бүхий гарын авлага хэвлүүлэн ажиллаж байна. “Авлигын эсрэг ...НЭГДЬЕ”, “Авлигагүй хамт олон” богино хэмжээний бичлэгийг Facebook, page-р шүгэл аяны зурагт хуудсыг байрлуулаад байна. 

1.2 Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	-Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; -Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх.	Жилдээ	Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан ажил олгогч, иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг Баянзүрх дүүргийн 1, 4, 17, 20, 30, 33 дугаар хороод давхардсан тоогоор нийт 1200 гаруй иргэд зөвлөгөө мэдээлэл хүргэх, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа анги, зэвсэгт хүний анги нэгтгэл зэрэг 12 байгууллагын 910 даатгуулагч, хувийн хэвшлийн нийт 25 ААНБ-ын 520 даатгуулагч нийт 1430 даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулан хамтран ажиллалаа. 2025.05.16-ны өдөр Сүхбаатарын талбайд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан “Ажилтай өрх-аз жаргалтай гэр бүл” нээлттэй өдөрлөгийн үеэр Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газраас оролцож иргэд, аж ахуй нэгжид нийгмийн даатгалын хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулан хамтран ажиллалаа.
1.3 Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах	- Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; -Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; - Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Жилдээ	Авлигын нийгмийн хор аюул, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор газрын цахим хуудсаар “Авлигын эсрэг ...НЭГДЬЕ” постыг 13 удаа сурталчилж 45-н албан хаагч хуваалцсан байна. Мөн Дүнжингаравын нэг цэгийн үйлчилгээ зөвлөгөө мэдээллийн төвийн 2 байцаагч нарын суух өрөө, 27 дугаар хорооны 1 байцаагч, 23 хорооны улайстай дахь нийгмийн даатгалын хэлтэст авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг зурагт хуудсыг нэг цэгийн зөвлөгөө мэдээллийн зурагтаар дүрсдүүлэн байршуулсан. 

1.4 Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	- Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; - Авлигыг мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; - Олон нийтэд түгээсэн байх.	Жилдээ	2025.03.21-нд Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 1 контентыг Facebook хуудсаар дамжуулан хүргэсэн. Тус контентыг 4197 үзэлт, Баянзүрх дүүргийн 43 хороодын группд шейрлэж хуувалцсан байна. 
--	---	---------------	---

Хоёр. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх

2.1 “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх;	-Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх; - Сонгосон чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх; -Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах; - Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх..	Жилдээ	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д даатгуулагч, хүн, ажил олгогч, нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөө, ... Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл /цаашид “салбар зөвлөл” гэх/-ийг аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэд ... ажиллуулна.”, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т ... салбар зөвлөл 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ... салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд нийгмийн даатгалын байгууллага, нутгийн захиргааны байгууллага, ажил олгогч, даатгуулагчийн төлөөлөл байна гэж заасан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 362 дугаар тогтоолоор батлагдсан “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/187 дугаар зөвлөмжийг үндэслэн 2024 оны 02 дугаар сарын 08-ны А/18 дугаар тушаалаар тус газраас 4, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос 1, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос 1, БЗД-н Засаг даргын тамгын газраас 2 тус тус албан хаагчдын бүрэлдэхүүнтэй байгуулж тус зөвлөл 2025 оны хагас жилээр 1 удаа хуралдаж 5 даатгуулагчтай холбоотой асуудал хэлэлцсэнээс 4 иргэнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж, 1 иргэнд шийдвэрлэхээс татгалзах талаар хариу өгсөн байна.
--	---	---------------	--

2.2 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	-Салбарт бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; -Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; - Үр дүнг тооцож, тайлагнасан байх	Жилдээ	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн А/90 тоот тушаалаар "Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн" бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тус зөвлөлд Нийгмийн даатгалын газрын дарга, Эрүүл мэндийн төвийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан орлогч дарга, Эрүүл мэндийн төвийн статистикч бага эмч, Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч, Эрүүл мэндийн төвийн Дотрын их эмч, Эрүүл мэндийн төвийн Мэдрэлийн их эмч, Эрүүл мэндийн төвийн Гэмтэл согог, Мэс заслын их эмч, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, Баянзүрх дүүргийн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг. • ЭХМК нь 38 ӨЭМТ, алслагдмал 20 дугаар хороо буюу Гачуурт тосгон, 11 хороо буюу Хонхор тосгон, нийслэлийн Багахангай дүүргийн иргэдэд эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааг үзүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах • 2025 оны эхний хагас жилийн байдлаар Дүүргийн хэмжээнд нийт 505 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шинээр тогтоож, сунгалт 1998, цуцлах 195, холбоотой бүх асуудлыг хариуцан ажилласан.
2.3 Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	-Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; -Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; -Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэлд холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.	Жилдээ	Нийт өргөдөл, гомдол – 631 Үүнээс: Цаасаар – 585 Цахим ERP 11-11 төвөөр – 46 Үүнийг төрлөөр нь ангилбал: Хүсэлт – 587 Гомдол – 41 Талархал – 3 ирсэн байна. Агуулгаар нь ангилбал: Тэтгэврийн асуудлаар – 19 Тэтгэмжийн асуудлаар – 45 Сайн дурын даатгалын асуудлаар – 229 Регистр, овог нэр нэгтгэх – 99 Нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх асуудлаар – 72 НДШ-н илүүх буцаах-150

			Гүйлгээ залруулах тухай – 17 Дундаж хоног 6, шийдвэрлэлт 100% байна.
Гурав. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах			
3.1 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах	-Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах; -Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; -Хэрэгжилтийг тайлагнах.	Жилдээ	МТТ-өөс шинээр нэвтэрч буй программ хангамжийн тохиргоо хийх даалгавар, үйл ажиллагааны чиглэлийг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Нийт 3 удаагийн цахим сургалтад хамрагдсан, 4 удаагийн тохиргоо хийх үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, системийн шинээр нэмэгдсэн дэд цэсүүдийг 3 удаагийн заавар, зөвлөмжийг холбогдох ажилтнуудад өгч ажилласан. Колл про үйлчилгээний дуудлага зохицуулах үйлчилгээний тохиргоо, холболт зэргийг нийт 3 удаа шинэчлэн хийж, тус компаний менежер Н.Урангоотой хамтран дуудлагын сүлжээнд бүрэн техникийн үзлэгийг хийж, тайлан гаргалттай холбоотой сургалтад хамрагдсан. Нийт ирсэн 10975 дуудлагын ярианы бичлэгийг 7 хоногоор нөөцлөн хадгалах шаардлагатай тохиолдолд тухайн мэдээллийн сангаас тодруулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Нийт байцаагч ажилтнуудад Програм хангамжийг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар 1 удаагийн сургалтын зохион байгуулж, програмын эрх олголтын бүртгэл, хяналтын карт хөтлөн ажиллаж байна.
3.2 Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;	-Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших; - Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан хэрэгжүүлсэн байх;	Жилдээ	Мэдүүлэг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ) нарт зориулсан сургалтыг АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс 2025.01.06-ны өдөр 09:00-12:30 цагт “Zoom”-р дамжуулан онлайнаар зохион байгуулсан сургалтад хамрагдсан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд хөрөнгө орлогын мэдүүлэг хэрхэн мэдүүлэх болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр газрын эрх бүхий 35 албан хаагчдад 2025.01.10-нд 403 тоотод сургалт зохион байгуулсан.

			2025.05.29-нд БЗД-н Насан туршийн суралцахуйн төвөөс зохион байгуулж байгаа “Хувийн авлигыг үл тэвчих соёл” аянд нэгдэж хамтран ажиллаж байна.
3.3 Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх	-Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх; -Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээ, хэрэгжүүлж буй арга хэмжээ онцлогт тохирсон байх.	Жилдээ	2024 оны 01 дүгээр сарын 01-нээс “Нийгмийн даатгалын ерөнхий хууль” хэрэгжиж эхэлсэнтэй хоблогдуулан 2024 оны 07 сард шинэ программ https://sicos.ndaatgal.mn/ бүрэн ашиглалтад орсон. Тус программ ашиглалтад орсноор иргэнд олон шат дамжлага гарахгүй нэг цэгийн байцаагчид матераил өгч бүртгүүлэх өөр байцаагч, мэргэжилтэнтэй (Тогтоолтын байцаагч, хяналтын байцаагч, санхүү) уулзаж цаг алдахгүй давуу талуудтай болсон эерэг талууд гарч байна.
3.3.1 Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг олон нийтэд тогтмол мэдээлэх	Төрийн аудитын байгууллагаас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын тайланг олон нийтэд ил тод мэдээлсэн байх,	Жилдээ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах, аудит хийж дүгнэлт гаргах ажлын тайлант оны хагас жил болон жилийн эцсийн байдлаар 2 удаа хийж гүйцэтгэж ажиллалаа. Тус ажлын хүрээнд шилэн дансны хуулийн дагуу Нийгмийн даатгалын байгууллагын санхүү /үйл ажиллагаа/-ийн нийт 183 /төсвийн гүйцэтгэл-71, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт-39, бусад-73/ мэдээллийг хуулийн хугацаанд бүртгэсэн, 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан хуулийн хэрэгжилт 99,4 хувьтайгаар хуулийг хэрэгжүүлж ажилласан талаар аудит хийж дүгнэлт гаргаж НДЕГ-т хүргүүлэн ажилласан байна.
3.3.2 Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх,	-2-оос доошгүй хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулсан байх, - Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд зохих арга хэмжээ авч үр дүнд хүрсэн байх, - Тайланд нотломжийг хавсаргасан байх,	Жилдээ	Нийгмийн даатгалын байгууллагын албан тушаалтны сахилга хариуцлага, ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх, албан хаагчтай холбоотой ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж, иргэд даатгуулагчдын эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах ажлыг зохион байгуулж байцаагч ажилтны харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой иргэд, даатгуулагчаас ирүүлсэн 6 гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж холбогдох газруудад хариуг хүргүүлж ажилласан байна. Монгол Улсын Их хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний хурлаар баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд нийт албан хаагчдын саналаар хэлтсийн Ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж, хорооны гишүүдийг баталгаажуулан ННДГ, НДЕГ-т хүргүүлж ажиллалаа. Нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудын ажлын байрны стандарт, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос 3

			удаагийн сургалтаар давхардсан тоогоор 125 байцаагч ажилтнуудыг хамруулж ажиллалаа. /Төрийн албан хаагчийн ёс зүйг хэмжээ, харилцаа хандлага болон үйлчилгээний стандарт, биеийн хэл/
3.3.3 Байгууллагын хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах;	-Мэдээллийг тухай бүрд нь шинэчлэх; -Тайланд шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Нийгмийн даатгалын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаарх ажлын хүрээнд: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай А/20 дугаар тушаал”-аар өгөгдсөн чиглэлийн хүрээнд нээлттэй мэдээллийг цахим хуудсанд, байгууллагын мэдээллийн самбарт байршуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд 48 бүлэг 56 нэр төрлийн мэдээллийн төрийн мэдээллийн цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж холбогдох мэдээллийг бүртгэх, байршуулах ажлыг тогтоосон хугацаанд байршуулан ажиллаж байна.
3.3.4 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг хийж үр дүнг тооцон ажилласан байх;	-Дотоод хяналт шалгалтыг хийсэн байх; -Дотоод хяналт шалгалтын мөрөөр арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 1.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Хувийн их дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулиудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж нийт 33 ААНБ-ыг хяналт шалгалтад хамруулж ажиллахаас 18 ААНБ-ын санхүүгийн баримтад хяналт шалгалтыг хийж улсын байцаагчийн шийдвэрийг танилцуулж, зөвлөмж, дүгнэлт өгч хяналт шалгалтын ажил үргэлжилж байна. 2.Газрын даргын баталсан 02 дугаарт удирдамжийн Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэмд заасан эрх үүргийн хүрээнд 2024 оны тус газарт нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн нийт 8700 ААНБ-ын тайлан (НД-7, НД-8)-г хүлээн авч баталгаажуулсан байдалд хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ, Шалгалтаар шимтгэл төлөлтийн тайланг хугацаа хоцроож хүлээн авч баталгаажуулсан, гарын үсэг, тамга тэмдэг дутуу, үлдэгдлийг баталгаажуулж тооцоо нийлсэн акт үйлдээгүй, хариуцлага тооцож хоцроосон тайланг хүлээн авч шийдвэрлээгүй, даатгуулагчийн цалин, төрлийн кодыг зөрүүтэй баталгаажуулсан зэрэг зөрчил дутагдал ирсэн байна.

			Дээрх зөрчлийг хяналт шалгалтын явцад арилгах, нийгмийн даатгалын улсын байцаагчийн албан шаардлага гардуулан өгч 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор арилгаж хариу ирүүлэх талаар үүрэг даалгавар өгч ажиллалаа. 3.Нийгмийн даатгалын байгууллагын хэрэгжүүлж байгаа ажлын байрын стандарт, 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн газрын даргын баталсан тушаалын хэрэгжилт, чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001-2015 стандартын хэрэгжилтийг шалгаж газрын нэгж (хэлтэс, тасаг)-дэд зөвлөмж хүргүүлж цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар даргын зөвлөлд танилцуулж алдаа, дутагдал анхаарах асуудлыг газрын даргын тушаалаар үүрэг даалгавар өгүүлэх санал хүргүүлж шийдвэрлүүлээ. 4.Газрын даргын баталсан дотоодын хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 2024 оны 01 сараас 2024 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд шинээр тогтоосон тэтгэврийн хувийн хэргийн тооллого болон тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгах ажлыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийж гүйцэтгэхээр хяналт шалгалтын ажил үргэлжилж байна.
--	--	--	--